

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал..	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.	Менежментийн захидал.....	10
3.1	Суралцагчдын хувсах зардал.....	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
5.	Хавсралт.....	17
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
МБСДС	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Б.НЯМДАВАА
ТАНАА

2019.03.05 № 06/564
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

071471

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ХХҮЕГ-ын дарга Б.Нямдаваа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Сангийн захирал нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 05-наас 03 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хэрэгжүүлэв.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 4/120 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийг төгсөгчид болон ажилгүй залуучууд, иргэдэд богино хугацаанд нийгэм, хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжил эзэмшүүлж ажлын байртай холбох замаар ажилгүйдэл, ядууралтай тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг удирдлага болгон ажилладаг.

Үйл ажиллагааны чиглэл:

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг дараахь байдлаар хуваарилан зарцуулна гэж заажээ. Үүнд:

- төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, түүнчлэн сурагчийн дотуур байрны нийт зардал
- өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг
- мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах зардал
- хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах зардал

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд

үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2018 оны нийт зардал 6,821.8 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 68.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд сонгосон хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцов.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/сая төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	3.9	
	Дүн	1	3.9	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 6,821.8 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 5,853.4 сая төгрөг буюу 85.8 хувьтай байгаа нь элсэгчдийн тоо буурснаас шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын шилэн дансны вебсайтад холбогдох мэдээллийг бүрэн оруулсан ба УАГ-ын Нийцлийн аудитын газраас хийсэн шалгалтаар зөрчил илрээгүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн бөгөөд хэрэгжилт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг

АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 СУРАЛЦАГЧДЫН ХУВСАХ ЗАРДАЛ

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд 40 МСҮТ-ийн 9890 суралцагчид нийт 5,857.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 5,853.4 сая төгрөг олгож 3.9 сая төгрөгийг суутган тооцсон нь санхүүжилт олгохдоо суралцагчдын тоог баталгаажуулаагүйгээс 72 суралцагчийн хувьсах зардлыг илүү шилжүүлсэнтэй холбоотой байна.

Энэ нь үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг баримталж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019- оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	2017 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>00.00</u>	<u>00.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	00.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	00.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>00.00</u>	<u>00.00</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>00.00</u>	<u>00.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	00.00	00.00
512	Хуримтлагдсан үр дүн	00.00	00.00
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,143,551,730.00	00.00
51220	Тайлант үеийн үр дүн	2,143,551,730.00	00.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>00.00</u>	<u>00.00</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,008,541,600.00	6,821,862,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,020,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	54,020,000.00	00.00
120009	Бусад орлого	54,020,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,954,521,600.00	6,821,862,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,954,521,600.00	6,821,862,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,954,521,600.00	6,821,862,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,864,989,870.00	6,821,862,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,864,989,870.00	6,821,862,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,981,731,548.00	5,853,453,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,981,731,548.00	5,853,453,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,981,731,548.00	5,853,453,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	883,258,322.00	968,408,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	883,258,322.00	968,408,900.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	883,258,322.00	968,408,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,143,551,730.00</u>	<u>00.00</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,143,551,730.00</u>	<u>00.00</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>9,008,541,600.00</u>	<u>6,821,862,200.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,020,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	54,020,000.00	00.00
120009	Бусад орлого	54,020,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,954,521,600.00	6,821,862,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,954,521,600.00	6,821,862,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,954,521,600.00	6,821,862,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>9,008,541,600.00</u>	<u>6,821,862,200.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,008,541,600.00	6,821,862,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,125,283,278.00	5,853,453,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,125,283,278.00	5,853,453,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,125,283,278.00	5,853,453,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	883,258,322.00	968,408,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	968,408,900.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	968,408,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	883,258,322.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	883,258,322.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>00.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-2,143,551,730.00	-2,143,551,730.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-2,143,551,730.00	-2,143,551,730.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	2,143,551,730.00	2,143,551,730.00
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,821,862,200.00	5,853,453,300.00	-968,408,900.00	85.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,821,862,200.00	5,853,453,300.00	-968,408,900.00	85.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,821,862,200.00	5,853,453,300.00	-968,408,900.00	85.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6821862200.00	5853453300.00	-968,408,900.00	85.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,821,862,200.00	5,853,453,300.00	-968,408,900.00	85.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,821,862,200.00	5,853,453,300.00	-968,408,900.00	85.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,821,862,200.00	5,853,453,300.00	-968,408,900.00	85.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	6,821,862,200.00	5,853,453,300.00	-968,408,900.00	85.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00	
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	16,031	9,890	-6,141	61.7
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	16,031	9,890	-6,141	61.7
632002	Хувийн МСУТ	16,031	9,890	-6,141	61.7

5. Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит</i>	
2019/03/13		Аудитын код:	САГ-2019/15/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6
1	Тайлант онд 40 МСҮТ-ийн 9890 суралцагчид нийт 5,857.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 5,853.4 сая төгрөг олгож 3.9 сая төгрөгийг суутган тооцсон нь санхүүжилт олгохдоо суралцагчдын тоог баталгаажуулаагүйгээс 72 суралцагчийн хувьсах зардлыг илүү шилжүүлсэнтэй холбоотой байна.	3.9	Зөвлөмж	2019 03.13	Нягтлан бодогч	Д.Билэгмаа
Нийт		3.9				

